

6

ИХ ЧИНГИС ХААНЫ ЭДИЙН ЗАСАГ, УДИРДЛАГЫН ЗАРИМ АСУУДАЛ

Ц.Цэвээн, Д.Энх-Отгон

Хураангуй.

13-р зууны Их Монгол улсын үеийн удирдлага, удирдах ажилтныг сонгон авдаг Чингис хааны арга зүйг тусган харуулав.

Энэ үеийн Их Монголд нийгмийн амьдралаас урган гарсан хоёр урсгал, хоёр жигүүрийн эрмэлзлийг тухайн үеийн олон улсын байдлаас шалтгаалан сонголт хийснийг харуулав.

Эл үгүүлэлд Монголын уламжлалт удирдлага эдийн засгийн зарим асуудлыг бид судалгааныхаа хүрээнд илэрхийлсэн болно.

Монгол нутаг дахь эртний төрт улсын үеэс эдийн засаг удирдлагын үйл ажиллагаа төрт ёсны зохион байгуулалттай болж эхэлсэн гэж үздэг. Бүр Хүннү гүрний үед аравтын зохион байгуулалтанд шилжсэн нь түүхэн баримт сурвалжуудаар нотлогддог.

Жил бүрийн намар цагт тодорхой товолсон үед Шаньюгийн газарт цуглан хүн ам, мал хөрөнгийн бүртгэлийг нэгтгэн улмаар алба татвараа хэлэлцэн тохирч түүнийгээ мөрдлөг болгодог байсан. Хүннүгийн үед дайн тулаан нь цэргийн дээд тушаалын захирагч дарга нарын эрх мэдлийг их болгож тэр дарга нарын хойч залгамжийг тогтмол нэгэн гэрээс өргөмжлөн сонгодог ёс нь эцгийн эрх тогтсон цагаас явагдаж үе залгадаг эрх мэдэл болон хувирч эхлээд хүлцэн зөвшөөрч, дараа нь шаардах, улмаар булаан авч үе залгадаг эрх мэдэл болж үе залгамжлах үндсийг тавьсан байдаг.

Эртний төрт улсууд Цэрэг Захиргааны зохион байгуулалттай байсан тул бүх аймгаа байлдааны нэгж, аравт, зуут, мянгат, түмтэд хувааж цэргийн сургууль байнга хийлгэж аймгийн бүх эрсийг байнгын цэрэг болгох бололцоог бүрдүүлжээ.

Нирун улсын тэргүүн Шелуньд “нэн хүчлэг” хэмээх чимэг бүхий хаан цолыг манай тооллын 402 онд өгч энэ үеэс хаан гэж төрийн тэргүүнийг нэрлэн цоллох болжээ. Энэ хаан аравтын системийг улам боловсронгуй болгон мянган хүн мянгат даргатай нэг хороо, зуун хүн зуутын даргатай нэг туг, арван хүн аравтын даргатай нэгэн баг болгон зохион байгуулжээ. Энэ үед буй болсон зохион байгуулалт, түүний нэр өнөө үед ч хэлбэрийн хувьд хэрэглэгдэж байдаг нь төрт ёсны уламжлал шинэчлэлтэй холбоотойн баталгаа мөн.

Бидний дээрхи дурьдсан зүйлс нь Их монгол улс бүрэлдэж түүнийг удирдан зохион байгуулсан Чингисийн үйл ажиллагаа нь өнө эртнийн эх сурвалжтай холбоотой.

Чингис хаан Их монгол улсаа байгуулсны дараа аравтын системийг улам боловсронгуй болгож, мянгатад тулгуурлан зохион байгуулалтаа хийсэн нь шинэхэн төрийн зангилаан дор нэгдсэн боловч жижиг овог аймгуудын бүлгэрхэг үзлийг өөрчилж чадсанд түүний ач холбогдол их юм. Учир нь тэдгээр жижиг овгуудыг тараан мянгатуудад хуваан, мянгатын захирагчаар хэн нэг язгууртныг биш харц гаралтай ч гэсэн монгол төрийн төлөө үнэнч зүтгэгч хүмүүсийг томилж мянганы газар нутгийг зааж өгсөн нь янз бүрийн овог аймгийн хүмүүс мянганыхаа төлөө зүтгэж Их засаг хуулиар заасан иргэний хүлээсэн үүргээ биелүүлдэг болсон нь нэгдэл нягтралыг сайжруулж овгийн “доворхог” үзлийг таслан зогсоосон нь одоо ч ач холбогдлоо алдаагүйгээр барахгүй 1990 оноос өмнө зохих шалгуураар тодорхойлогдсон удирдах ажилтан монгол орны хаана ч үүрэг гүйцэтгэдэг байсан нь дээрхи үйлийн үргэлжлэл гэлтэй байлаа.

Их монгол улсын эдийн засгийн байдлыг авч үзэхдээ юуны өмнө Чингис хааны эдийн засгийн бодлого зохицуулалт, үйл ажиллагааг нарийвчлан судлах зайлшгүй шаардлагатай.

Чингис хааны эдийн засгийн бодлогыг судлахдаа Монголын феодалийн үйлдвэрлэлийн аргын онцлог, болон Их монгол улс бүрэлдэн тогтох үеийн монгол төрийн зүтгэлтнүүдийн хувийн аж төрөл, аж ахуйн байдлыг тухайн үед өрнөж байсан үйл явцтай холбон цогцолбор байдлаар судалбал үнэнд төдийчинээ ойртох магадлалтай юм.

Монголын феодалийн үйлдвэрлэлийн арга нь өөрийн өвөрмөц онцлог талуудтай байв. Үүнд:

1. Дэлхийн ихэнх улс орнуудад газар тариалан, гар үйлдвэрлэлийн суурь дээр тулгуурлаж феодализм хэрэгждэг бол Монголд эрчимгүй мал аж ахуйд суурилан хэрэгжсэн.
2. Боолын нийгмийн задралын үр дүнд бүрэлддэг бол Монголд хүй нэгдлийн задралын үр дүнд буй болсон.
3. Нэгэн төрлийн аж ахуй нэлэнхүйгээрээ эрхэлдэг учир дотоодын зах зээл сул хөгжилтэй байсан зэрэг онцлогтой байв.

13-р зууны тэр үед монгол нутагт

1. Феодалийн үйлдвэрлэлийн харилцаа ялсан
2. Их монгол улс байгуулагдсан
3. Улс орноо бүрэн тохижуулж амжилгүй дайнд татагдан орсон явдал зэрэг нь түүхийн тэр нэг зэрвэсхэн хугацаанд аугаа ийм гурван чухал үйл явдал давхцан явагдсан

Ер нь их монгол улс байгуулагдсан тэр үед монгол улсын дээд удирдлагад хоёр том бүлэглэл буй болсон гэх үндэслэлтэй. Бүх аймгуудыг дараа, дараалан нэгтгэх явцад асар уудам газар нутаг, их хэмжээний ард түмэн, эд хөрөнгө бүрэлдэн нэгдэж тэр их зүйлийг удирдан зохион байгуулах эрх зүйн үндсийг буюу “Их засаг хууль”-ийг их хуралдайгаар батлан мөрдөж эхэлсэн нь Монгол төр, Монгол улсын хувьд асар том ололт, их дэвшил байв. Энэ их ололтод тулгуурлан өөрийн тогтоосон хил хязгаарын дотор, эдийн засгийн дотоод зохион байгуулалт тухайлбал, дотоод, гадаад худалдаа, татвар төлбөр, гааль гэх мэт эдийн засгийн хөшүүргэд тулгуурлан улс орондоо амгалан тайван аж төрлийг төвхнүүлж эдийн засгийн арга ажиллагаагаар удирдахад тулгуурласан эдийн засаг, аж ахуйн бүлэг удирдлага буй болжээ.

Нөгөө талд жижиг ханлиг, овог, аймгуудыг нэгтгэн нэгэн тугийн дор хураахад хэдэн зуун мянган дайчдаас бүрдсэн тухайн үедээ дэлхийд бараг байхгүй асар том морьт арми бүрдсэн бөгөөд аравт, зуут, мянгатын удирдлагаас бүрдсэн цэргийн бүлэглэл буй болсон бөгөөд уг бүлгийнхний үзэл баримтлал нь бусдыг уулгалан довтолж, газар нутгаа тэлэх, эд зүйл олзлох, мөн эзлэгдсэн орнуудаас татвар төлбөр авах эрмэлзэл бүхий байсан нь илэрхий. Үүнээс учиглан үзэхүл цэргийнхний удирдлагын том бүлэглэл буй болжээ гэх үндэстэй.

Ийм хүчирхэг эсрэг тэсрэг үзэл бүхий хоёр том бүлэглэлийн уулзварт Чингис хаан эцсийн шийд гаргах хариуцлагатай хурц асуудалтай тулгарсан байна. Түүхэн сурвалжуудын тэмдэглэлээс учиглан үзвэл Чингис хаан аж ахуйн бүлэглэлийн талд баттай зогсож хаяа зэргэлдээ улстай найрсаг харилцаа тогтоох нэн ялангуяа худалдааны харилцаа тогтоож өргөжүүлбэл “эсгий туургат” ард түмний бэлчээрийн мал аж ахуйн илүүдэл зүйлсийг “шороон ханат” суурин түмний гзар тариалан, гар урлалын зүйлсээр солилцоо хийж аль, аль талын хэрэгцээг хангах хэтийн бодлого баримтлан Хорезм руу анхны худалдааны том аяныг зохион байгуулан явуулсан бөгөөд тэр үеийн гадаад худалдаа нь улс төр, эдийн засаг, дипломат харилцааны үндсэн хэлбэр байсан нь түүхэн баримтаар нотлогдож байна.

Гэтэл Хорезм болоод Төв Азийн улс орнуудад улс төр, эдийн засаг, соёлын харилцааг хэрэгжүүлэхдээ хүч түрсэн бодлого, давамгайлж байсны уршгаар Хорезмын тал Монголын худалдааны том бүлгийг дээрэмдэж, худалдаачдыг цаазалсан нь Монголын аж ахуйн бүлэглэлийнхний гонсойлгосон төдийгүй Чингис хааны гадагш явуулах бодлого эрс

өөрчлөгдөн “алтан аргамж”-ийг тасалсан тухайн оронд нэхэл хатуутай хандахад цэргийнхний бүлэглэлийн шахалт шаардлага ч хүчтэй нөлөөлсөн нь магад юм.

Тэр үеийн монголыг хүрээлэн байсан улс орны бодлогоос хамаарч улс гэрээ эдийн засгийн бэхжилт баттай болоогүй үед дайнд татагдан орсон нь монголын ирээдүйн хувь заяанд ч сайнаар нөлөөлөөгүй юм. Гэхдээ дэлхийн зүүн бөмбөрцөгийн олон улс орны хөгжилд Монголын нөлөө олон янзын арга хэлбэрээр туссан нь тохиолдлын зүйл биш юм.

Энэ нь Их Чингис хааны улс төр эдийн засаг, удирдлагын бодлого нь монгол улсынхаа хүрээнд зогсохгүй дэлхийн менежментийн ухаанд оруулсан их хувь нэмэр болсон гэх үндэстэй. Үүнд:

- Тухайн үедээ ардчилалын дээд хэлбэр болсон “хуралдай” хэмээх парламентийг үүсгэн байгуулсан
- Эрх зүй бол менежментийн аргуудын тогтолцооны нэг гол элемент байдаг учир, хуралдайгаар баталж гаргасан “Төрийн их засаг” хэмээх хууль нь үндсэн хуулийн суурийг тавьсан
- Төрийн их заргачийг тохоон томилсноор шүүх тогтолцооны эхийг бүрдүүлсэн
- Эрдэмтэд ухаантнуудаар “Цэцдийн зөвлөл” хэмээхийг байгуулж, төрийн бодлого боловсруулахад ашиглаж байсан
- Хангамж, нөөцийн зарчмыг “гээг урт” нэртэйгээр үйл ажиллагаандаа хэрэглэж байжээ.
- “Хэвтүүл” хэмээх төрийн хамгаалалтын албыг буй болгосон
- “Хишигтэн” хэмээх мэргэшсэн торгон цэргийн цөм буй болгосон нь цэрэг-феодалийн байгуулал бүхий улс оронд энэ нь цэргээр зогсохгүй тухайн үеийн боловсон хүчин бэлтгэх суурь болсон гэх үндэстэй.

Чингис хааны өөрийнх нь онцлог шинжүүдийн нэг нь хэвшмэл бишээр сэтгэх чанарт байдаг. Өөрийн анхны нөхөд болох “Турхагууд”-ыг нэг хүрээнд барьж байх эдийн засгийн үндэс нь хадам эцэг Дай сэцний хөрөнгөнд тулгуурласан байна. Доктор Д.Лхашид энэ тухай “..... хадам эцэг Дай сэцний туслалцаа авч болохыг бодож олсон явдал гэж үзэх үндэслэлтэй. Охиноо бэлэвсрээсэй гэх сэтгэлтэй эцэг байдаггүй гэдгийг тэрээр тооцоолсон явдал билээ. Дай сэцэн хоол хүнс, цэрэг зэвсэг, юу хүссэн бүгдээр нь тусалсан байдаг” гэжээ.

Чингис өөрийгөө харван шархдуулсан хүний мөн чанарыг мэдэх гэж “Миний ам цагаан хул морины хүзүүг хэн харвасан бэ?” гэхэд олзлогдогсдын дотроос нэг нь “би барьсан газраа алдадгүй билээ. Ам цагаан хул морины хүзүүг би харвасан” гэж үнэнийг хэлсэн Зургаадайг

ихэнх судлаачид үнэнээ хэлсэнд нь өршөөж өөрийн дотны жанжин болгосон гэж үздэг.

Тэгвэл энд тогтож ажиглая.

- Би барьсан газраа алдадгүй билээ гэж харваач хэлж байна. Тэгвэл яагаад алахаар биш шархдуулхаар харвасан байдаг байна. Үүнд л хамаг учир нь байна. Харваач Чингистэй ойртон нөхөрлөхийг боддог байжээ. Хэрвээ тийм л юм бол шууд яваад ирчихгүй юу гэж хэн хүнгүй хэлнэ л дээ. Харваач тэр эсрэг талаас Чингисийн талд шууд ирвэл ердийн нэг урвагчаар бодох эсвэл энгийн нэг цэргээс цааш гаргахгүй байсан байх. Иймд харваач Чингисийн үйлдэлд шүүмжлэлтэй хандсан. Тэр шүүмжлэл нь Чи эзэн хаан байж ердийн цэрэг шиг хамгаалалтгүй байлдаж болохгүй, энэ байдал чамайг үхэлд хүргэнэ гэдгийг сануулж шархдуулж харваад дараа нь өөрөө олзлогдон үнэнийг хэлсэн нь Чингис хаан мөн чанарыг гүнзгий сэтгэн үздэг учир сайн ойлгож түүнийг өрлөг жанжинаа болтол өргөмжилсөн байна. Чухамдаа би харвасан юм гэж үнэнээ хэлсэн бол харваач цаазлуулах нь дамжиггүй. Үүнээс үзэхүл их хаан аливаа асуудлыг маш богино хугацаанд задлан шинжилдэг чадвар гойд байсныг нотолж байна.

Арван гуравдугаар зууны үед бэлчээр нуудлийн мал аж ахуй тухайн үеийн хамгийн хүчирхэг үйлдвэрлэлийн хэрэгсэл байжээ. Мал аж ахуй нь хүний хэрэглээг төгс хангадаг тухайлбал мах, сүүг нь идэж, ууж, арьсаар нь хувцаслаж ноосоор нь гэрээ бүрэхийн ялдамд бод мал тэр үеийн уналга тээврийн хэрэгцээг бүрэн хангах чадвартай байжээ. Тиймдээ ч дэлхийн зүүн хагасын 40 гаруй улс орны 100 гаруй сая хүнийг байлдан дагуулах хүчирхэг материаллаг нөхцөл болжээ.

Энэ үеийн хүчирхэг үйлдвэрлэлийн хэрэгсэл бүхий нийгмийг хэн нэг хүчтэн удирдах нь зайлшгүй энэ зүй тогтлыг хэрэгжүүлэгч Чингис бол харин санамсаргүй нь юм. Гэхдээ нийгмийн хэрэгцээ өөрийн их удирдагчийг төрүүлдэг жамтай. Эзэн хааны эрх мэдлийн төлөө монголын нөлөө бүхий хүмүүсийн өрсөлдөөн дунд бараг есөн настайгаасаа тэмцэлд орж дийлэн гарч ирсэн нь Чингис хааны оюун санаа, бие бялдырын давуугаар шалгарсан үзүүлэлт юм.

Нөгөө талаар зохион байгуулалтын аравтын систем нь мэдээлэлийг бие биендээ түргэн хугацаанд дамжуулж бусдаас дэмжлэг туслалцаа авах бусдад тусламж үзүүлэх мөн удирдлагын чиг үүргийг хүлээн авч биелүүлэх болон үйл явдалтай уялдан гарах асуудлыг удирдлагад эргэж мэдэгдхэд түргэн шуурхай боломж бүрдүүлдэг байсан учир энгийн цагт аж ахуйг хөтлөх, дайн байлдааны цагт хүчийг маневрлах өргөн боломжтой зэрэг давуу талыг монголчууд ухаалаг ашигладаг байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Бэлчээр нүүдлийн мал аж ахуйн хөдөлгөөнт чанар нь Монголын их цэргийн хангалтыг цаг алдалгүй, тасралтгүй хэрэгжүүлснээр алс газрын аян дайн хийх, ялалт байгуулах нөхцлийг бүрдүүлж байжээ.

Чингисийн удирдлагын нэг онцлог гэвэл түүний зохион байгуулалтын үндсэн доодоос дээд нэгж хүртэл зохион байгуулсан аравт юм. Энэ нь харахуй, сонсохуй, хүртэхүй, хэрэгжүүлэхүйн хамгийн оновчтой хэмжээтэй холбоотой. Чухамдаа 9 нь цэрэг 10 дахь нь ахлагч байжээ. Их гүрний дээд удирдлага ч ийм буюу 9 өрлөг 10 дахь нь Чингис хаан өөрөө байсан нь аравтын онцлог юм.

Дүгнэлт:

- Их Чингис хааны удирдлага, зохион байгуулалтын аравтын систем нь Монгол нутаг дахь эртний төрт улсуудаас үе дамжин ирсэн болох нь түүхэн эх сурвалжуудаар нотлогдох бөгөөд түүнийг улам боловсронгуй болгож мянгатад тулгуурлан зохион байгуулалтаа хийсэн нь шинэхэн төрийн зангилаан дор нэгдсэн жижиг овог аймгуудын бүлгэрхэг үзлийг өөрчилж чадсан. Мөн мэдээлэлийг бие биендээ түргэн хугацаанд дамжуулах, энгийн цагт аж ахуйг хөтлөх, дайн байлдааны цагт хүчийг маневрлах өргөн боломжтой зэрэг давуу талуудыг өөртөө шингээх ажээ.
- Монголын феодалийн үйлдвэрлэлийн арга нь өөрийн өвөрмөц онцлог талуудтай байв. Тухайлбал ихэнх улс орнуудад газар тариалан, гар үйлдвэрлэлийн суурь дээр тулгуурлаж феодализм хэрэгждэг бол Монголд эрчимгүй мал аж ахуйд суурилан хэрэгжсэн, боолын нийгмийн задралын үр дүнд бүрэлддэг бол Монголд хүй нэгдлийн задралын үр дүнд буй болсон, нэгэн төрлийн аж ахуй нэлэнхүйгээрээ эрхэлдэг учир дотоодын зах зээл сул хөгжилтэй байсан зэргийг дурьдаж болно.
- Чингис хаан бие биенийхээ эсрэг тэсрэг үзэл бүхий аж ахуйн болон цэргийнхний гэсэн 2 том бүлэглэлийн уулзварт эцсийн шийд гаргах хариуцлагатай хурц асуудалтай тулгарсан нь нэг талаас “Их засаг” хэмээх үндсэн хуулийн эхийг тавьж аж ахуйг төвхнүүлэх, нөгөө талаас тухайн үеийн хүрээлэн буй улс орнуудын өдөөн хатгалаг нь тусгаар тогтнолоо цэргийн хүчээр хүлээн зөвшөөрүүлэх шалтгаан болжээ.
- Чингис хаан улс орныхоо гадаад, дотоод аль ч бодлогодоо бусдыг эзлэн түрэмгийлэх санаа агуулаагүй нь аливаа дайн тулааны үүдэл нь бусдаас 100 хувь хамааралтай байдгаар бүхий л зүйл дээр ажиглагддаг
- Чингис хаан агуу сэтгэл зүйч байж эсрэг талыгаа бодитойгоор үнэлж өөрийнхөө үйл ажиллагаанд ч татан оролцуулж чаддаг, аливаа